



21

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 21

Номгон

Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын  
амжилттай суралцах суурь чадварыг эзэмшүүлэх,  
хоцрогдлыг арилгах ажил, арга хэмжээний  
хөтөлбөр батлах тухай

Баянхонгор аймгийн хэмжээнд I ангийн 67 бүлгийн 2057 сурагч байгаагаас аймгийн төвд 27 бүлгийн 1037, сумын төвд 40 бүлгийн 168, малчин 852, огт холбогдох боломжгүй 255 сурагч байна. Харин II ангийн 67 бүлгийн 2164 сурагч байгаагаас аймгийн төвд 28 бүлгийн 1141, сумын төвд 39 бүлгийн сурагчдаас сумын төвд 66, малчин 957, огт холбогдох боломжгүй 287 сурагч байна гэсэн судалгаа байна.

Мөн дэлхийн нийтэд тархаад байгаа ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд хичээл сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулж байгаагаас шалтгаалан I ангийн үсгээ нүдэлж тогтоосон 1770, үсгээ нүдлээгүй байгаа 253, холбон унших аргаа олсон 1464, унших аргаа олоогүй 487, бичгийн хэв тогтсон 1687, бичгийн хэв тогтоогүй 320, тоо, цифрээ нүдлээгүй байгаа 1911, нэмэх, хасах үйлдэл хийж чаддаг 1210, нэмэх, хасах үйлдэл хийж чаддаггүй 666 сурагч байгаа бол II ангийн шууд уншдаг 865, үелэж уншдаг 876, үсэглэж уншдаг 298, огт уншиж чадахгүй байгаа 122, нэг минутад уншиж байгаа үгийн дундаж 33,6, зөв бичих чадвар маш сайн байгаа 707, зөв бичих чадвар хангалттай байгаа 870, зөв бичих чадвар хангалтгүй байгаа 554, 100 дотор нэмэх, хасах үйлдлийг маш сайн хийж чаддаг 936, 100 дотор нэмэх, хасах үйлдлийг хангалттай хийж чаддаг 781, 100 дотор нэмэх, хасах үйлдэл хийж чадахгүй байгаа 368 сурагч гэсэн үзүүлэлт гараад байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын үед болон бүх нийтийн бэлэн байдлын хөл хорионы дэглэм тогтоож хичээл сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулан явуулж байгаа нь ерөнхий боловсролын сургуулийн нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын унших, бичих, математикийн болон бусад хичээлээр эзэмшигдэх мэдлэг, ойлголт дутуу дулимаг, хангалтгүй эзэмшигдэх, суралцахуйн суурь чадвар төлөвшихгүй байх, улмаар цаашид амжилттай суралцахад нь бэрхшээл үүсэх эрсдэлт нөхцөл байдал бий болгож байна.

D:/2021/Alban bichig/togtool-2021

0121020

Иймд нэг болон хоёрдугаар ангийн сурагчдыг хоцроохгүй сургах сургалтын оновчтой технологи бүтээх, эцэг эх, ах, эгч нарынхаа тусламжтай зайнаас суралцахад нь шаардлагатай сургалтын цахим ба хэвлэмэл хэрэглэгдэхүүн материалаар хангах замаар сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлэх, хоцрогдлыг арилгах, суралцахуйн суурь чадварыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын амжилттай суралцах суурь чадварыг эзэмшүүлэх, хоцрогдлыг арилгах ажил, арга хэмжээний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар ханган бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эцэг эхийн оролцоонд тулгуурлан зохион байгуулж, сургалтын үр дүн зорилтод сурагч бүрд хүрч буй эсэхэд хяналт тавин хичээлийн хоцрогдлыг бүрэн арилгах арга хэмжээ авч дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэдээлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Д.Энхжаргал/, аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ц.Энхтөр/ нарт даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

**НЭГ БОЛОН ХОЁРДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН  
АМЖИЛТТАЙ СУРАЛЦАХ СУУРЬ ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ,  
ХОЦРОГДЛЫГ АРИЛГАХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**Нэг. Үндэслэл**

Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын үед болон бүх нийтийн бэлэн байдлын хөл хорионы дэглэм тогтоож хичээл сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулан явуулж байгаа нь ерөнхий боловсролын сургууль нь нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын унших, бичих, математикийн болон бусад хичээлийн мэдлэг, ойлголт хангалтгүй эзэмшигдэх, суралцахуйн суурь чадвар төлөвшихгүй байх, улмаар цаашид амжилттай суралцахад нь бэрхшээл үүсэх эрсдэлт нөхцөл байдал бий болгож байна. Иймд суралцахуйн суурь чадвар эзэмшүүлж, агуулгын хоцрогдолыг арилгах, суралцахуйн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг үндэслэл болгов.

**Хоёр. Зорилго**

Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдыг хоцроохгүй сургах сургалтын оновчтой технологи бүтээх, эцэг эх, ах, эгч нарынхаа тусламжтай зайнаас суралцахад нь шаардлагатай сургалтын цахим ба хэвлэмэл хэрэглэгдэхүүн материалаар хангах замаар сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлэх, хоцрогдлыг арилгах, суралцахуйн суурь чадварыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлнэ.

**Гурав. Зорилт**

3.1 Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын унших, бичих болон математикийн мэдлэг чадвар эзэмшилтийн байдал, түвшинг тогтоож, түүнд үндэслэн сургалтын чанарыг сайжруулах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх

3.2 Эцэг эхчүүдийг хүүхэдтэйгээ ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэн хамтран ажиллах замаар тэдний оролцоог нэмэгдүүлэх

3.3 Цахим хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн бүтээж хүргэх замаар гэртээ аав, ээж, ах эгч нарынхаа тусламжтайгаар суралцах бололцоог бүрдүүлэх.

**Дөрөв. Үйл ажиллагаа**

4.1 Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдад сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн суурь чадварыг бүрэн эзэмшүүлэх ажлыг 4 үе шаттайгаар зохион байгуулна.

4.1.1 I шат-02 дугаар сард “Аав ээжтэйгээ хамт” цахим сургалт, сурах бичгээ ашиглан суралцах үйл ажиллагаа

4.2.2 II шат-Сурагчдын мэдлэг чадварын ялгаатай байдал болон агуулгын хоцрогдлыг арилгах давтлага хичээллүүлэх үйл ажиллагаа / 3-5 сард Бямба гараг бүрд/

4.2.3 III шат-3уны сургалт 06 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 01 хүртэл өдөр бүр 22 хоног

4.2.4 IV шат-Цаашид эдгээр үйл ажиллагааны үр дүнг тогтвортой байлгах, сурагчдад суралцахуйн суурь чадварыг бүрэн эзэмшүүлэх олон талт ажил арга хэмжээг зохион байгуулах

Зорилт 1-н хүрээнд: /Хичээл танхимаар хичээллэхгүй үед, хичээллэх үед/

1.1 Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын унших, бичих, болон математикийн мэдлэг чадварын түвшинг тогтоох судалгааг авах, дүгнэлт гаргах.

1.2 02 дугаар сарын 01-ээс танхимаар хичээллэхгүй тохиолдолд цахим сургалт явуулах, цахимаар холбогдох техникийг боломжгүй сурагчдад сурах бичгээ ашиглан суралцах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх,

1.3 Нэг болон хоёрдугаар ангийн багш нарт “Цахим хичээл бэлтгэн явуулах” чадварыг нэмэгдүүлэх онлайн сургалт явуулах. Нэгдүгээр ангийн 67, хоёрдугаар ангийн 67, нийт 134 багшид ZOOM, CLASSROOM, GOOGLEMEET, TEAMS программ ашиглах арга зүйн сургалтыг онлайнаар зохион байгуулна.

1.4 “Аав ээжтэйгээ хамт” цахим хичээл зохион байгуулах. Хүүхэд бүрт цахимаар суралцуулах бэлтгэл ажлыг анги удирдсан багш эцэг эхтэй хамтран бэлтгэсэн байна. /компьютер, ухаалаг утас, интернет сүлжээ, бусад тоног төхөөрөмж ашиглахыг судалж бэлтгүүлэх/ Цахим хичээлийг 7 хоног бүрийн Баасан, Бямба гарагт үдээс өмнө 13:00-15:00 математик, үдээс хойш 16:00-18:00 цагт монгол хэлний хичээлийн агуулгын хоцрогдлыг арилгахад чиглэсэн хичээлийг сурагч, эцэг эхэд цахимаар орно. Үүнд: 1-р ангийн Үсэглэлийн бүх хичээл, /6 цагийн хичээл/, математикийн тоо, цифр таниулах, 20 хүртэлх тооны дотор аравт хэтрүүлэхгүй нэмэх, хасах үйлдлийн хичээл /6 хичээл/, 2-р ангийн монгол хэлний унших, бичих чадварыг дэмжсэн /6 хичээл/, математикийн хүрдээр үржүүлэх, хуваах 6 хичээл бэлтгэх.

1.5 Сурагчдын ерөнхий чадварын ахицыг тооцох судалгаа хийнэ. 2 сард зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнг тооцон шинжилгээ хийнэ.

Зорилт 2-ын хүрээнд:

2.1 Эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа гаргах /ухаалаг утас, бусад төхөөрөмж хөдөө орон нутагт ашиглагдах байдлын талаар/

2.2 Эцэг эхчүүдийг хүүхэдтэйгээ ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагад ажилладаг нэг болон хоёрдугаар ангийн хүүхэдтэй эцэг, эхэд 7 хоног бүрийн Баасан гарагийн 14-18 цаг хүртэл ажлын цагийг зохицуулалт хийх /сум орон нутагт сумын засаг даргад/ албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх.

2.3 Эцэг эхэд хүүхдийн хичээлийг хийлгэх заавар зөвлөгөө өгөх цахим сургалт, уулзалтыг 8 удаа хийнэ.

2.4 “Эцэг эхийн үлгэр дуурайл, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх нь” аян өрнүүлэх. Үүнийг ДЗОУБ, НХМА-тай хамтран нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

2.5 Хүүхэдтэйгээ сайн ажиллаж байгаа эцэг эхийг урамшуулж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа

Зорилт 3-н хүрээнд:

3.2 Нэг болон хоёрдугаар ангийн гол хичээлүүдээр сурагч бие даан гүйцэтгэх дасгал даалгаврын дэвтэр /бүтээгдсэн дэвтэр, материалыг захиалан авч өгч болно/

3.3 Эцэг эх, ах, эгч нарт зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн материал, сурах бичгийг ашиглан хичээллэх гарын авлага, “сурагчийн үйл ажиллагааг чиглүүлж хөтлөхөд туслах арга зүй” зөвлөмж боловсруулна.

## II ШАТАНД

Зорилт 1-н хүрээнд:

1.1 Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын сурах бичгээ ашиглан суралцсан үеийн байдал болон II улиралд суралцсан сурлагын түвшинд оношлох үнэлгээ хийнэ. /унших, бичих, болон математикийн мэдлэг чадварын түвшинг тогтоох/

1.2 Сурагчдын ялгаатай байдал, түвшинд тохирсон давтлага хийх агуулга хүрээг тогтоож, төлөвлөгөө гаргана.

1.3 Долоо хоног бүрийн Бямба гарагт 10:00-14:00 математик, монгол хэлний хичээлээр давтлага хийнэ. Анги удирдсан багш нар ангийн сурагчдыг түвшинчлэн хоцрогдсон агуулгаар нь давтлага өгнө. 1 дүгээр ангийн монгол хэлний хичээлээр үелж унших, шууд унших, ойлгож унших, зөв бичих, цэвэр бичих /нийт 8 хичээл/, математикийн хичээлээр 100-гийн дотор аравт хэтрүүлэн нэмэх, хасах үйлдлийн хичээл /8 хичээл/, бусад хичээлийг интеграцчилж, /2 төрлийн тус бүр/. 2-р ангийн монгол хэлний унших, зөв бичих чадварыг дэмжсэн /8 хичээл/, математикийн хүрдээс гадуур үржүүлэх, хуваах 8 хичээл бэлтгэх.

Зорилт 2-ын хүрээнд:

2.1 “Эцэг эхийн үлгэр дуурайл, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх нь” зөвлөгөөг цахимаар зохион байгуулна.

2.2 Хүүхдийг хялбар аргаар уншуулж сургах, бүтэн үгээр уншуулж сургах арга, алдаагүй зөв бичүүлж сургах арга зүйг эцэг эхэд өгөх, зөвлөмж, гарын авлага бэлтгэн хэрэгжүүлж, хамтран ажиллах

Зорилт 3-н хүрээнд

3.2 Нэг болон хоёрдугаар ангийн дээрх хичээлүүдээр сурагч бие даан гүйцэтгэх дасгал, даалгаврын дэвтэр /бүтээгдсэн дэвтэр, материалыг захиалан авч өгч болно/

### III ШАТАНД

Зорилт 1-н хүрээнд:

1.1 1-5 ангийн жилд судлах агуулгын эзэмшсэн байдалд оношлох үнэлгээ хийнэ. /унших, бичих, болон математикийн мэдлэг чадварын түвшинг тогтооход анги дэвших шалгалтын үнэлгээнд үндэслэнэ/

1.2 Зуны сургалтын агуулгын хүрээг тогтоон, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах.

1.3 Ажлын 5 өдөрт 10:00-14:00 цагт математик, монгол хэлний хичээлээр багш өөрийн ангийн сурагчдын онцлогт тулгуурлан давтлага хийнэ. 1-р ангийн монгол хэлний хоцрогдсон агуулгаар /30 цагийн хичээл/, математикийн хичээлийн хоцрогдсон агуулгаар /30 цагийн хичээл/, бусад хичээлийн агуулгыг интерацчилан /20 цагийн хичээлийг тус бүр зуны сургалтаар зохион байгуулна/

1.4 Хөтөлбөрийн хүрээнд ангийн сурагчдыг бүрэн хамруулан хоцрогдлыг арилгаж, стандарт хангалтыг ахиулан ажилласан багшийг урамшуулан туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

Зорилт 2-ын хүрээнд:

2.1 Эцэг эхчүүд хүүхдээ зуны сургалтанд хамруулах боломж нөхцлийг бүрдүүлэх /хөдөө явуулахгүй байх, хүндэтгэх шалтгаангүйгээр чөлөө авахгүй байх, 1, 2 дугаар ангийн хүүхдийг гараас гарт аргачлалаар хүргэж өгөх, авах гэх мэт/

2.2 Зуны сургалтыг тасалдуулахгүй тууштай хамруулан, холбогдох заавар зөвлөгөөг авч анги удирдсан багштай хамтран ажиллана. /Хүүхдэд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж өгөх гэх мэт/

Зорилт 3-н хүрээнд:

3.1 1-5 ангийн дээрх хичээлүүдээр сурагч бие даан гүйцэтгэх дасгал даалгаврын дэвтэр /эсвэл нэмэлт даалгавар гарын авлага/

### IV ШАТАНД

Бүтээлч уншлага, уншлагын чанаруудыг эзэмшүүлэх төрөл бүрийн уралдаан гэх мэт уламжлалт олон талт үйл ажиллагааг тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулна.

### Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1 Санхүүжилт: ДЗОУБ, Орон нутгийн уул уурхай эрхэлдэг ХХК-уудын хандив дэмжлэг гэх мэт

#### Зургаа. Зардал

##### 6.1 Багшийн зуны сургалтын ажлын цалин хөлсний тооцоо

№	Цалингийн сүлжээний шатлал	үндсэн цалин	дундаж цалин	нэг өдрийн хөлс (n/22)	нэг цагийн хөлс (n:8x1.5)	1 өдөр ажиллах цаг	1 өдрийн цалин	Ажиллах өдөр	Нэг багшийн цалин
1	1-5 жил ажилласан багш	749728	787008	35773	6707	4 цаг	26830	13	348,790
2	6-11 жил ажилласан багш	755608							
3	12-16 жил ажилласан багш	770545							
4	17-24 жил ажилласан багш	808442							
5	25-аас дээш жил ажилласан багш	850717							

##### 6.2 Сурагчдад тараах гарын авлага хийх бичгийн цаасны тооцоо

Анги	Сурагчдын тоо	Хэмжих нэгж (ширхэг)			Нийт цаас (боодол)	1 боодол цаасны үнэ	Нийт үнэ ₮
		1 сард (1 сурагчын хэрэглэх цаасны тоо)	Нийт сурагч (1 сарын хэрэглээ)	2,3,4,5-р сар			
1	255	40ш	10200	40800	81	12000	2,028,000
2	287	40ш	11480	44320	88		
3	101 багш				10,000 нэгж		1,010,000
НИЙТ							3,038,000

##### 6.3 Зорилтот сумдын багш сурагчдад олгох дата

№		Хөтөлбөрт хамрагдах			1 хүнд өгөх ДАТА(₮)	
		хүүхдийн тоо	багшийн тоо	нийт		
1	Баянговь	117	4	121	10,000	1210000
2	Баянлиг	182	6	188		1880000
3	Баянцагаан	150	5	155		1550000
4	Богд	138	4	142		1420000
5	Бууцагаан	134	4	138		1380000
6	Бөмбөгөр	131	4	135		1350000
7	Жинст	135	6	141		1410000
		987	33	1020		10 00 000₮

##### 6.4 Зөвхөн 1 болон 2 дугаар ангийн багш нараар тооцвол

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	нийт	ДЗОУБ
1	Багшийн	134 багш	348,790	46,737,860	

	цагийн хөлс				
2	Гарын авлага	169 боодол	169*12000	2,028,000	
3	DATA олгох	101 багш	10000	1,010,000	
4	DATA олгох	1020	987сурагч*10000=9870000 33 багш*10000=330000		10,200,000 төгрөг
5	Нийт			49,775,860	

Долоо. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэмжлэгийн багийг сургууль бүрдээр байгуулж, бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, дотоод хяналт тавих ажлыг зохион байгуулах

7.2 Төрийн бус байгууллагын оролцоотой хөндлөнгийн хяналтыг зохион байгуулах

Найм. Хөтөлбөрийн үр дүнг тооцох

8.1 Хөтөлбөрийн зорилт бүрийн хүрээнд хийгдэх ажил, үйл ажиллагаа бүрэн хийгдэж сурагчдын агуулгын хоцрогдол арилсан байдал

8.2 Нэг болон хоёрдугаар ангийн сурагчдын унших, бичих болон математикийн мэдлэг чадварын түвшин тогтоох үйл ажиллагааг 7-14 хоногийн хугацаанд эцэг эхтэй нь холбогдон авч сурагчдын ахиц амжилтыг тооцох, суралцахуйн суурь чадвар хэрхэн эзэмшиж байгаа байдалд дүгнэлт гарах бөгөөд үүнд үндэслэнэ.

8.3 Танхимын сургалтын хэлбэрт шилжсэн үед сурагчдын сурлагын амжилтыг тогтоох шалгалт авч үр дүнг тооцно.

8.4 Эцэг эх, иргэд, сургуулийн удирдлага, багш нарын сэтгэл ханамжийг судалж тооцно.